



ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 0/66.

Улаанбаатар хот

Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын  
хөгжлийн газрын орон тоо, албан тушаалын нэршил,  
ангилал, зэрэглэл, дүрэм, бүтэц батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9 дэх хэсэг, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн Газрын 2019 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны "Зөвшөөрөл олгох тухай" 386 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны "Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн жишиг бүтэц батлах тухай" А/10 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2022 оны улсын төсөв батлагдсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан жишиг бүтэц, батлагдсан төсөв, орон тоонд үндэслэн тус аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газрын орон тоо, албан тушаалын нэршил, ангилал, зэрэглэлийг 1 дүгээр хавсралтаар, дүрмийг 2 дугаар хавсралтаар, бүтцийн зураглалыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын үйл ажиллагааны дүрэм, зорилго зорилт, чиг үүрэгт нийцүүлэн батлагдсан төсөв, цалингийн сан, орон тоонд багтааж, салбарын хүний нөөцийг тогтвортой ажиллуулж төрийн албаны хууль тогтоомж, дүрэм журмыг чанд сахиж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газрын дарга /Ц.Оюунбилэг/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн Захиргааны удирдлагын газрын дарга /Ш.Чинбат/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/03 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.БАТДОРЖ

5200207




Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын  
2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 4/56 дугаар  
тушаалын 1 хавсралт

Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын  
орон тоо, албан тушаалын нэршил, ангилал, зэрэглэл

№	Албан тушаал	Албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэглэл	Орон тоо
<b>Нэг. Удирдлага -1</b>				
1	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга	Ахлах түшмэл	T3-10	1
<b>Хоёр. Гүйцэтгэх албан тушаалтан /13/</b>				
1	Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл	T3-6	1
2	Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл	T3-6	1
3	Гэр бүлийн хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл	T3-6	1
4	Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл	T3-6	1
5	Хүүхдийн эрхийн улсын байцаагч	Дэс түшмэл	T3-6	1
6	Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл	T3-5	1
7	Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл	T3-5	1
8	Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл	T3-5	1
9	Зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл	T3-5	1
10	Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл	T3-5	1
11	Нягтлан бодогч	Мэргэжлийн албан хаагч	TY-8	1
12	Архив, бичиг хэргийн ажилтан		TY-5	1
13	Нярав		TY-4	1
<b>Гурав. Залуучуудын хөгжлийн төв /1/</b>				
1	Залуучуудын хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан ажилтан	Мэргэжлийн албан хаагч	TY-6	1
<b>Дөрөв. Түр хамгаалах байр /3/</b>				
1	Нийгмийн ажилтан /зохицуулагч/	Гүйцэтгэх	TY-6	1
2	Үйлчилгээний ажилтан		TY-6	2
<b>Тав. Байр ашиглалт /2/</b>				
1	Жолооч	Туслах	TY-3	1
2	Үйлчлэгч		TY-1	1
<b>Нийт</b>				<b>20</b>





## АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь (цаашид “газар” гэх) хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын орон нутгийн тогтолцоог удирдан зохион байгуулах, залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд чиглэгдсэн хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мөн.

1.2. Газрын үйл ажиллагааны эрхэм зорилго: “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангахад оршино”

1.3. Газар нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенциуд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Тэргүүлэгчдийн шийдвэр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, захирамж, шийдвэрүүд болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

1.4. Газар нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөртэй уялдуулан үйл ажиллагаагаа явуулна.

1.5. Газар нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан бэлэгдэл (лого)-ийг ашиглах бөгөөд архив, албан хэрэг хөтөлгөөний тухай хуулийн дагуу тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас ашиглах, төрийн санд данстай байна.

1.6. Газар нь үйл ажиллагаандаа төрийн албаны болон хүүхдийн эрхийг хамгаалахад баримтлах зарчмуудыг мөрдлөг болгохоос гадна үр дүнд суурилсан мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээ, гэр бүл төвтэй хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын үйлчилгээг эрхэмлэж, хууль дээдлэх, шударга ёс, ил тод, авлига, хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэх зэрэг хуульд заасан зарчмыг баримтлан ажиллана.

### ХОЁР. ГАЗРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Газар нь гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орон нутаг дахь салбар байгууллага бөгөөд аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг байна.

2.2. Газрын дүрэм, бүтэц, орон тоог Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлах ба газрыг газрын дарга удирдаж, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч нартай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, биелэлтийг тайлагнаж ажиллана.

2.3. Аймаг, сумын Хүүхдийн төлөө болон Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги, Хүүхдийн элч, хүн амын бүлгүүдийн өмнө үүрэг хүлээгчдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

2.4. Газар нь Хүүхдийн зуслан, Хүүхэд хөгжлийн ордон, төвүүд, Гэр бүлийг дэмжих төв, Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв, Залуучуудын хөгжлийн төвтэй байж болох бөгөөд удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.



2.5. Газар нь хэлтэс, албагүй байна. Газрын даргын эзгүйд захиргаа, хүүхэд, гэр бүл, залуучуудын асуудал хариуцсан аль нэг ахлах мэргэжилтнээр түр орлон гүйцэтгүүлж болно.

2.6. Газрын даргыг Хүүхэд хамгааллын тухай хууль болон Төрийн албаны тухай хуулийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга томилж чөлөөлөх, газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан ажилтан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

2.7. Газрын дарга нь эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал, дүрэм, журам, заавар баталж, байгууллагын хэмжээнд мөрдөх, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын бүрэн бүтэн байдал, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж төрийн захиргааны манлайлыг хэрэгжүүлж ажиллана.

2.8. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд зөвлөх, дэмжлэг үзүүлэх зорилгоор орон тооны бус "Зөвлөх баг" ажиллуулж болно. Зөвлөх багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын даргын тушаалаар батална.

2.9. Газар нь хөдөлмөрийн дотоод журамтай байна. Хөдөлмөрийн дотоод журмыг холбогдох хууль тогтоожийн хүрээнд боловсруулж, хамт олны хурлаар хэлэлцэн баталж, мөрдөнө.

2.10. Газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, орон нутгийн Засаг даргын Тамгын газар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

### **ГУРАВ. ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

3.1.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр орон нутагт холбогдох хууль, тогтоомж, Ерөнхийлөгч, Улсийн Их Хурал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тогтоол, шийдвэр, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.1.2. Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд салбар дундын болон олон улс, төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, түншлэлийг бэхжүүлэх чиглэлд манлайлал үзүүлж ажиллана.

#### 3.2. Гэр бүлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа:

3.2.1. Гэр бүлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, сурталчлах;

3.2.2. Гэр бүлийн таатай орчин бүрдүүлэх, нийгмийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх замаар зорилтот гэр бүлийн аж байдлыг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

3.2.3. Гэр бүлийн хөгжлийг дэмжих, боловсрол олгох, нийгмийн үйлчилгээг үзүүлэх байгууллагуудын салбар дундын зохицуулалтыг хангах, орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд "Эцэг эхийн зөвлөл" байгуулах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын гүйцэтгэлд нь хяналт тавих;

3.2.4. Гэр бүлийн хөгжлийг дэмжсэн санал санаачлагуудыг дэмжих, гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээний нэр төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх;

3.2.5. Гэр бүлийн хөгжлийг дэмжих орон нутгийн хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;

3.2.6. Сум, багийн хамтарсан баг, Түр хамгаалах байр, Хөршийн холбоог мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;



3.2.7. Гэр бүлийн аливаа дарамт хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, архидалтыг бууруулах, гэр бүл дэхь хүний эрхийн зөрчлийг арилгахад чиглэсэн төсөл, хөтөлбөр санаачлах, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулах;

3.2.8. Гэр бүлийн харилцаа, үнэ цэнэ, дархлааг сайжруулах, гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулах төсөв хөрөнгийг нэмэгдүүлэхэд санаачлага гаргаж ажиллах, анхаарах;

3.2.9. Өрх, гэр бүлийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа бүхий шинэ санал, санаачилгуудыг дэмжих, гэр бүлд зөвлөн туслах үйлчилгээний орчин, нөхцөлийг бий болгож, үр дүнд хүргэх, гэр бүлд ээлтэй байгууллага, хамт олныг алдаршуулах, шагнаж урамшуулах;

3.2.10. Жендерийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн гишүүд нийгэм, эдийн засаг, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцох, хөгжлийн үр шимээс тэгш хүртэх, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах;

### 3.3. Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа:

3.3.1. Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх хууль тогтоомж эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, сурталчлах бөгөөд тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.3.2. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагыг чадавхижуулах, хүүхдийг оролцооны аргад суралцуулах, идэвхижүүлэх, урамшуулах замаар хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих сургалт, мэдээлэл, нөлөөллийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;

3.3.3. Эрх нь зөрчигдсөн хүүхдийг төрийн үйлчилгээгээр хангах, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

3.3.4. "Хүүхдийн төлөө зөвлөл", "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо", "Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги"-ийн гишүүд, Хүүхдийн элчийг мэдээлэл, арга зүйн удирдлагаар хангах, хууль тогтоомжинд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;

3.3.5. "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг эцэг эх олон нийтэд сурталчлан таниулах, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах, хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарт нийцүүлэн тэднийг хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлөөр хангахад чиглэгдсэн зэрэг ажлыг зохион байгуулах;

3.3.6. Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийг сайжруулах чиглэлээр өөрсдийнх нь оролцоонд тулгуурласан аргачлалыг хэрэгжүүлж, тэдний өөрийн үнэлэмжийг дээшлүүлэхэд онцгой анхаарч, амьдрах ухаан, Монгол ахуй, уламжлал, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэхэд эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгч, олон нийтийн оролцоог хангаж ажиллах;

3.3.7. Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх чиглэлийн дугуйланг дэмжих, тухайн хичээлийн жилийн үргэлжлэх хугацааны зорилтын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудтай үр дүнтэй хамтран ажиллах;

3.3.6. Хүүхдийн асуудлаар тухайн нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хуулийн этгээд, иргэний үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.3.7. Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллага, зуслан, ордон, төвүүдийн судалгаа, мэдээллийг нэгтгэх замаар мэдээллийн сан бий болгон дүгнэлт хийж, олон нийтэд сурталчлах, хамтран ажиллах;



3.3.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах, тэдгээрийн хөгжил төлөвшил, хамгааллыг сайжруулах, нийгэмшихүйн чиглэлээр гаргасан санал, санаачлагуудыг дэмжих, хамтран ажиллах;

3.3.9. Хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээд, хувь хүн, хүүхдийг алдаршуулах, шагнаж урамшуулах;

3.4. Залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн үйл ажиллагаа:

3.4.1. Залуучуудын хөгжил, оролцоог хангах төрийн бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, сурталчлах;

3.4.2. Залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт хэрэгцээнд тулгуурласан сонирхлын клуб, зөвлөл, бүлэг, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах;

3.4.3. Залуучуудын хувь хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан, эрүүл мэнд, аюулгүй амьдрах, хөгжих орчин нөхцлийг дэмжих чиглэлээр холбогдох талуудтай хамтран ажиллах, залуучуудын боловсролыг дэмжих, эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйлчилгээг өргөжүүлж, нийгэмд өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх, оролцоог дэмжих механизмыг бий болгох;

3.4.4. Орон нутгийн түвшинд залуучуудын чиглэлээр шаардлагатай судалгаа, шинжилгээ хийж, хэрэгцээ, үр дүнд суурилсан үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

3.4.5. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих;

3.5. Гэр бүл, хүүхэд, залуучуудтай ажилладаг ажилтнуудыг чадавхижуулах, тгний нөөцөд тулгуурласан, хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх:

3.5.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудтай ажилладаг салбар бүрийн /сургуулийн, халамжийн, эрүүл мэндийн, сумын, багийн болон бусад салбарын/ нийгмийн ажилтнуудыг чадавхижуулах, тэднийг мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөн туслах, ажиллах арга барил, шилдэг туршлагыг бий болгон хөгжүүлэх;

3.5.2. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын асуудлаар үүрэг хүлээдэг төрийн болон иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгжийг дэмжих, байгууллагын дэргэдэх зөвлөл, сэтгэл зүйчдийн баг, бусад холбоодтой харилцаа холбоо тогтоож, тэдгээрийн хүрээг нэмэгдүүлж төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх;

3.5.3. Аймаг, сумын "Хүүхдийн төлөө зөвлөл", "Хамтарсан баг", "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо", "Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл", "Хүүхдийн элч" болон байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, идэвхижүүлэх, арга зүйн удирдлагаар хангах ажлыг тасралтгүй зохион байгуулах;

3.6. Мэдээлэл, судалгаа, хяналт үнэлгээ:

3.6.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын өмнө тулгамдаж байгаа аливаа асуудал, зөрчлийг хянах мэдээлэл, судалгааны дэвшилтэт технологиуд суурилсан гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллыг сайжруулах бодлого, шийдвэрт нөлөөлөхүйц судалгаа, мэдээллийн санг бий болгож, үйлчилгээний үр дүнг олон нийтэд хүртээмжтэй, ил тод мэдээлж, олон нийтийн хяналтын тогтолцоог төлөвшүүлэх;

3.6.2. Холбогдох байгууллага, дээд шатны байгууллага, албан тушаалтнуудыг гэр бүл, хүүхэд, залуучуудын талаарх мэдээлэл судалгаагаар хангаж, тодорхой шийдвэр гаргуулах, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавихад хамтран ажиллах;



3.6.3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаарх аливаа мэдээллийг хүлээн авах, бүртгэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх;

3.6.4. Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, байгууллагын болон ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулах;

## **ДӨРӨВ. ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ**

### 4.1. Газар нь дараах эрхийг эдэлнэ.

4.1.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааг аймаг, орон нутагт хэрэгжүүлэхтэй холбогдсон санал, санаачлагыг хуулийн хүрээнд холбогдох талуудад тавьж шийдвэрлүүлэх

4.1.2. Газрын дэргэдэх зуслан, хүүхэд хөгжлийн болон залуучуудын ордон, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, залуучуудын хөгжлийн зөвлөл, гэр бүлийг дэмжих төвүүдийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, холбогдох дүрэм, журмуудын хүрээнд эрхэлж буй үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.3. Газрын чиг үүрэг, эрхэлсэн асуудалтай холбоотой мэдээлэл цуглуулах, судалгаа хийж санал, дүгнэлтийг холбогдох талуудад хүргүүлэх, баримт материалыг төрийн захиргааны болон бусад байгууллагуудаас тогтоосон журам, зааврын дагуу гаргуулан үйл ажиллагаандаа ашиглах;

4.1.4. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр хуульд заасан хугацаанд шаардлагатай төсвийн төслийг танилцуулж улсын болон орон нутгийн төсөвт тусган үйл ажиллагаагаа зохион байгуулах;

4.1.5. Төрийн болон орон нутгийн өмчийн гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээрх ашиглаж буй барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой санал, дүгнэлт гаргах, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

4.1.6. Ажилтан, албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, туршлага судлуулах зэрэг сургалт, аялалын зохистой арга хэлбэр, хамрах хүрээг өргөжүүлэх талаар үе шаттай арга хэмжээг авах;

4.1.7. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн улмаас хохирсон хүүхэд, гэр бүлийн талаарх мэдээллийг хүлээн авах, цуглуулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахуулахаар холбогдох газарт уламжлан, шийдвэрлүүлэх;

4.1.8. Сум, харьяа төвүүдийн ажилтан, албан хаагчдийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг тодорхойлж, ажилтан, албан хаагчдыг сонгон шалгаруулж томилох, чөлөөх, мэргэшүүлэх, удирдлага арга зүйгээр хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах;

### 4.2. Газар нь дараах үүргийг хэрэгжүүлнэ.

4.2.1. Газар нь гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенциуд болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, орон нутгийн болон өөрийн удирдлагын байгууллагуудыг дэмжих, мэдээлэх, нэгдсэн зохицуулалтаар хангах үйл ажиллагааг аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулах;

4.2.2. Газар нь Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хамаарал бүхий зорилтыг хэрэгжүүлэх;



4.2.3. Газар нь дэргэдэх нэгж болон аймгийн хэмжээнд гэр бүл, хүүхэд, залуучуудтай ажилладаг ажилтнууд, сумдын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд, салбар бүрийн нийгмийн ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, чадавхижуулах чиглэлээр холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

4.2.4. Газрын дэргэдэх Хүүхдийн төлөө зөвлөл, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл болон Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги, Хүүхдийн элч, Хүүхдийн зуслан, Хүүхэд болон залуучуудын хөгжлийн ордон, Гэр бүлийн хөгжлийг дэмжих төв, Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, Залуучуудын хөгжлийн төвийг нэгдмэл удирдлага, зохион байгуулалтаар хангах;

4.2.5. Гэр бүл, хүүхэд, залуучуудын онцлог, нөхцөл байдал, хэрэгцээнд суурилсан хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, иргэд олон нийтийн санаачилга, хөдөлгөөнийг өрнүүлэх ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлэх;

4.2.6. Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэд, зорилтот гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан хөгжил, хамгааллын үйлчилгээний журам, заавар, хөтөлбөр, төлөвлөгөө, төслүүдийн хэрэгжилтийг хангахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, тогтолцоог бэхжүүлэх;

4.2.7. Гэр бүл, хүүхэд, залуучуудын нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдэнтэй холбогдсон байгууллага, иргэдийн санал, өргөдөл гомдлыг хүлээн авч, өөрөө буюу холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

4.2.8. Газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд тогтоол, захирамж, журам, хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгийн төсөл боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн болон Тэргүүлэгчдийн Хурал, Засаг дарга, Засаг даргын зөвлөл, холбогдох дээд шатны байгууллагуудад уламжлан хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

4.2.9. Газар нь ажилтан, албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг бодитой шийдвэрлэх, мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хамт олныг төлөвшүүлэхэд чиглэгдсэн ажлыг санаачлан зохион байгуулах;

4.2.10. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын бодлого, үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээг чанартай боловсруулж, цаг хугацаанд холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэх, орон нутагт чиглэлийн дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, хүүхдийн эрхийн хэрэгжилт, зөрчлийг хянах, хүүхэд хамгааллын тайлан, мэдээ гаргах;

4.2.11. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих, энэ чиглэлээр үр бүтээлтэй хамтран ажиллаж буй иргэн, хуулийн этгээдийг алдаршуулах, шагнаж урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах, дэмжих, сайн туршлагыг түгээж ажиллах

4.2.12. Бусад хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллана.

## **ТАВ. ХАРИУЦЛАГА**

5.1. Газар нь хууль тогтоомж, дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

## **ЗУРГАА. БУСАД**

6.1. Энэхүү дүрэмд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.



Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн 4/5.6 дугаар тушаалын хавсралт

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ЗУРАГЛАЛ**

